



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 4/53

Ховд

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн "Жаргалант сумын Бугат, Хайрхан багийн гэрэлтүүлэг"-ийн ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Гантөмөр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын газрын Авто замын улсын байцаагч

Ц.Цогтбаяр – Жаргалант сумын Засаг даргын орлогч

У.Пүрэвдорж – Ховд "Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ий Ерөнхий инженер

Л.Дорждэрэм – Жаргалант сумын хот тохижуулах газрын дарга

Б.Түмэнжаргал – Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Ц.Сувдаа –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн.

2.Ховд аймгийн "Жаргалант сумын Бугат, Хайрхан багийн гэрэлтүүлэг"-ийн ажлын ажлын даалгаварын дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /С.Гантөмөр/ – д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

05 00417  
D/Zax-A/53-Da